



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/18

Өмнөдэлгэр сум

**Үндсэн цалингийн нэмэгдэл олгох
журам батлах тухай**

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.6 дахь хэсэг, Эрүүл мэндийн салбарын 2020-2021 оны “Хамтын нэмэлт хэлэлцээр”-ийн 3.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн албан хаагчдын үндсэн цалингийн нэмэгдэл олгох журмыг нэгдүгээр, ажлын үр дүн гүйцэтгэлийн үнэлгээний загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын багийн ахлагч (Э.Ган-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.АРИУНТУНГАЛАГ

Өмнөдэлгэр сумын эрүүл мэндийн төвийн
даргын 10-ны 2-дугаар сарын 12-ний
өдрийн 9-дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

Үндсэн цалингийн нэмэгдэл олгох журам

2316293602
УЛСЫН БАГУУТ 9074056

Нэг: Нийтлэг үндэслэл

- 1.1. Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16.4.6 дахь хэсэг, Эрүүл мэндийн салбарын 2020-2021 оны "Хамтын нэмэлт хэлэлцээрийн 3.3 дахь" заалтыг үндэслэн Эрүүл мэндийн төвийн албан хаагчийн салбарын 60 хувийн нэмэгдлийг дүгнэж олгохдоо энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Байгууллагын дарга төрийн албан хаагчийн салбарын нэмэгдлийг дүгнэж, шалгуур үзүүлэлтийг хангасан төрийн албан хаагчид олгоно.
- 1.3. Салбарын нэмэгдэл олгоход шаардагдах хөрөнгийг байгууллага жил бүр төсөвтөө тусгана.

Хоёр. Ажлын үр дүн, гүйцэтгэлээр ажилтанд салбарийн
нэмэгдэл олгох

- 2.1. Эрүүл мэндийн салбарын үндсэн цалингийн нэмэгдлийг ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 60 хүртэлх хувиар сар бүр тооцож олгоно.
- 2.2. Эрүүл мэндийн салбарийн үндсэн цалингийн нэмэгдлийг олгохдоо энэ журмын 2.3-т заасан шалгуур үзүүлэлтийг баримтлан ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэж, тухайн жилийн цалингийн санд багтаан энэ журмын 2.5, 2.7-т заасан шийдвэрийг үндэслэн олгоно.
- 2.3. Эрүүл мэндийн салбарийн үндсэн цалингийн нэмэгдэл олгоход дараах шалгуур үзүүлэлтийг баримтлана.

	Үр дүнгийн үндсэн шалгуур	Үндсэн тодорхойлох үзүүлэлт	шалгуурыг тусгай	Үнэлгээ хувиар /%/
Эрүүл мэндийн ажилтанд тавигдах шалгуур үзүүлэлт				
Эрт илрүүлэг	1. Артерийн гипертензи 2. Чихрийн шижин хэв шинж II	1.1 зорилтот бүлгийн иргэдээс сар бүр 10-20 хүн хамруулах		

	3. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг 4. Хөхний хорт хавдарын эрт илрүүлэг	2.1 Чихрийн шижин, хэв шинж II үзлэгт 10-20 хүн хамруулах 3.1 Умайн хүзүүний эсийн шинжилгээ сар 1-2 хүн хамруулах 4.1 Хөхний хавдарын эрт илрүүлэгт 10-20 хүн хамруулах	40%
Ёс зүйн хэм хэмжээ	1. Ёс хэм хэмжээг мөрдөх	1.1 Харилцаа хандлагын зөрчилгүй байх 1.2 Хувцаслалтын хэм хэмжээг мөрдөх хяналтын хуудсаар 90 доошгүй хувь байх 1.3 Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гомдол гаргаагүй байх	10%
Олон нийтийн идэвхи оролцоо	1. Байгууллагын ярианд тогтмол суух 2. Байгууллагын дотоод сургалтанд бүрэн хамрагдах 3. Олон нийтийн уулзалтанд оролцох	Хүндэтгэх шалтгаанаас бусад үед дотоод яриа, сургалт, олон нийтийн үйл ажиллагаанд цагтаа бүрэн оролцсон байх	5
Үүрэг даалгаврын биелэлт	Үүрэг даалгаварын биелэлт	1. Харьяалагдах албан тушаалтны өгсөн үүрэг даалгаварын биелэлт 2. Бусад байгууллагаас ирсэн албан бичгийн хариуг хугацаанд нь илгээх	5
Нийт хувь			60

- 2.4. Ажлын үр дүн, гүйцэтгэлийг байгууллагын удирдлагын баг үнэлж, хувь хүнд танилцуулж дүгнэлт гаргана.
- 2.5. Хамт олны хурлаас гаргасан дүгнэлтийг үндэслэн ажилтанд Эрүүл мэндийн салбарын нэмэгдлийг олгох шийдвэрийг байгууллагын дарга гаргана.
- 2.6. Салбарын нэмэгдлийн сарын бүрийн 20-нд дүгнэж цалинтай хамт олгоно.
- 2.7. Байгууллагын даргын Эрүүл мэндийн салбарын нэмэгдлийг албан тушаалд томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана.

УДИРДЛАГЫН БАГ

Ажлын үр дүн гүйцэтгэлийн үнэлгээний хүснэгт

[illegible]